



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 1/338

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 7, 12 дугаар байрны орчин нөхцөл, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 05 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу "Бүлээн оргил" ХХК-тай 53 000 000 /тавин гурван сая/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай
2. Ажлын гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.
3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Бүлээн оргил" ХХК /Ж.Батжаргал/-д үүрэг болгосугай.
4. Тус ажлын санхүүжилтийг аймгийн төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ